



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/118/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК

Гүйцэтгэх захирал С.Энхтөр

Утас: 95957791

Цахим хаяг: director@mindug.mn

Аудитор О.Цагаан

Утас: 99519341

Цахим хаяг: soo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
5.2 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.25 № 94

танай _____-ны № _____-т

**СҮХБААТАР АЙМГИЙН
ТҮВШИНШИРЭЭ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.ГАНТӨМӨР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой байдлын, мөнгөн гүйлгээний, санхүүгийн үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, төсвийн гүйцэтгэл, тодруулга тайлангуудад стандартад заагдсан тохиргоо бичилтүүд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 229,566.4 мянган төгрөг буюу 48 хувиар өссөн нь улсын төсвийн санхүүжилт 163,082.3 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилт 41,525.1 мянга, "Орон нутгийн хөгжлийн сан"-аас 17,497.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, "Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр"-ийн дагуу 9,714.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй орлого авсан нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, 12 зорилтын 46 арга хэмжээний гүйцэтгэл 88.0 хувийн биелэлттэй байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>45,178,568.50</u>	<u>84,605,910.91</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	33,559,670.91
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	33,559,670.91
3121	Төгрөг	-	33,559,670.91
31211	Төрийн сангийн харилцах	-	33,559,670.91
35	БАРАА МАТЕРИАЛ	45,178,568.50	51,046,240.00
354	Хангамжийн материал	44,980,568.50	51,046,240.00
35410	Бичиг хэргийн материал	2,862,345.00	2,845,540.00
35420	Аж ахуйн материал	41,268,700.00	48,146,100.00
35440	Түлш, шатах тослох материал	849,523.50	-
35460	Хүнсний материал	-	54,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,412,135,168.00</u>	<u>2,370,193,291.34</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,412,135,168.00	2,370,193,291.34
392	Биет хөрөнгө	2,405,405,168.00	2,356,004,291.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,179,707,538.00	2,179,707,538.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,617,553.54)	(116,961,791.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	148,951,534.00	160,851,534.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,001,519.59)	(51,139,116.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,299,155.90	61,736,755.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,750,698.61)	(34,485,652.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	184,387,785.00	184,901,285.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,571,073.16)	(28,606,262.12)
393	Биет бус хөрөнгө	6,730,000.00	14,189,000.00
39301	Програм хангамж	-	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(25,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,730,000.00	12,714,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,457,313,736.50</u>	<u>2,454,799,202.25</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>277,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	277,000.00
413	Өглөг	-	277,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	277,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,457,313,736.50</u>	<u>2,454,522,202.25</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,457,313,736.50	2,454,522,202.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	132,821,121.00	132,821,121.00
51101	Өмч: - төрийн	132,821,121.00	132,821,121.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,252,021,761.88	2,249,230,227.63
51210	Өмнөх үеийн үр дүн	2,326,597,557.78	(232,604,474.62)
51220	Тайлант үеийн үр дүн	(74,575,795.90)	2,481,834,702.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72,470,853.62	72,470,853.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,457,313,736.50</u>	<u>2,454,799,202.25</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	478,025,200.00	3,192,218,383.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,638,500.00	2,512,423,736.50
120	Нийтлэг татварын бус орлого	2,638,500.00	2,512,423,736.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,638,500.00	2,512,423,736.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	485,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,638,500.00	2,511,938,736.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,386,700.00	679,794,647.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	403,128,600.00	566,210,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	566,210,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	403,128,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,058,100.00	113,583,747.38
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,058,100.00	113,583,747.38
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	552,600,995.90	710,383,681.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,600,995.90	710,383,681.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523,116,767.64	699,356,188.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,212,356.52	386,153,908.47
210101	Үндсэн цалин	208,535,292.26	277,451,684.71
210102	Нэмэгдэл	83,577,077.37	85,636,893.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	25,099,986.89	23,065,330.50
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,016,100.00	51,789,300.00
210201	Тэтгэврийн даатгал	30,270,700.00	35,216,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,186,300.00	4,143,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,549,100.00	3,314,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	637,200.00	828,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,372,800.00	8,286,300.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,317,511.72	67,894,530.81
210301	Гэрэл, цахилгаан	7,239,246.22	11,011,841.31
210302	Түлш, халаалт		

		25,729,565.50	39,602,689.50
210303	Цэвэр, бохир ус	6,348,700.00	17,280,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,306,245.00	-
210401	Бичиг хэрэг	500,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	510,750.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	338,800.00	-
210404	Ном, хэвлэл	72,900.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	883,295.00	-
2105	Нормативт зардал	28,845,830.00	84,944,084.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	208,900.00	-
210502	Хоол, хүнс	28,265,930.00	84,944,084.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	371,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,880,000.00	11,940,500.00
210604	Урсгал засвар	7,880,000.00	11,940,500.00
2107	Томилолт, зочны зардал	85,400.00	-
210702	Дотоод албан томилолт	85,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,622,500.00	1,109,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,622,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,109,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,830,824.40	95,524,165.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	984,600.00	15,166,089.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,902,800.00	3,081,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,943,424.40	77,276,976.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,484,228.26	11,027,492.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	11,027,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	11,027,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	492.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	492.69
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,484,228.26	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,484,228.26	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(74,575,795.90)</u>	<u>2,481,834,702.25</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(74,575,795.90)</u>	<u>2,481,834,702.25</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>475,386,700.00</u>	<u>680,279,647.38</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	485,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	485,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	485,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	485,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,386,700.00	679,794,647.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	403,128,600.00	566,210,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	566,210,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	403,128,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,058,100.00	113,583,747.38
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,058,100.00	113,583,747.38
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>445,902,471.74</u>	<u>628,882,376.47</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,902,471.74	628,882,376.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,902,471.74	617,854,883.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,212,356.52	386,153,908.47
210101	Үндсэн цалин	208,535,292.26	277,451,684.71
210102	Нэмэгдэл	83,577,077.37	85,636,893.26
210104	Урамшуулал	25,099,986.89	23,065,330.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,016,100.00	51,789,300.00
210201	Тэтгэврийн даатгал	30,270,700.00	35,216,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,186,300.00	4,143,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,549,100.00	3,314,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	637,200.00	828,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,372,800.00	8,286,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,603,035.22	67,045,007.31
210301	Гэрэл, цахилгаан	7,239,246.22	11,011,841.31
210302	Түлш, халаалт	26,015,089.00	38,753,166.00
210303	Цэвэр, бохир ус	6,348,700.00	17,280,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	1,905,850.00	-
210401	Бичиг хэрэг	420,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	510,750.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	338,800.00	-
210404	Ном, хэвлэл	96,900.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	538,900.00	-
2105	Нормативт зардал	30,226,830.00	84,998,684.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	148,900.00	-
210502	Хоол, хүнс	28,265,930.00	84,998,684.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,812,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,750,000.00	12,154,500.00
210604	Урсгал засвар	8,750,000.00	12,154,500.00
2107	Томилолт, зочны зардал	85,400.00	-
210702	Дотоод албан томилолт	85,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,427,100.00	1,109,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,427,100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,109,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,675,800.00	14,603,784.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	893,000.00	11,273,884.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,782,800.00	3,329,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	11,027,492.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	11,027,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	11,027,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	492.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	492.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>29,484,228.26</u>	<u>51,397,270.91</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	17,837,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	17,837,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	17,837,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	17,837,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=====	<u>(17,837,600.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	29,484,228.26	33,559,670.91
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	33,559,670.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	2,326,597,557.78	0.00	2,531,889,532.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	2,326,597,557.78	0.00	2,531,889,532.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-74,575,795.90	0.00	-74,575,795.90
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	2,252,021,761.88	0.00	2,457,313,736.50
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	2,252,021,761.88	0.00	2,457,313,736.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-2,484,626,236.50	0.00	-2,484,626,236.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	-232,604,474.62	0.00	-27,312,500.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,481,834,702.25	0.00	2,481,834,702.25
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,821,121.00	72,470,853.62	2,249,230,227.63	0.00	2,454,522,202.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	710,479,700.00	646,719,483.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	710,479,700.00	646,719,483.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	699,452,700.00	635,692,483.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,932,100.00	386,153,908.47
210101	Үндсэн цалин	349,381,900.00	277,451,684.71
210102	Нэмэгдэл	55,939,800.00	85,636,893.26
210104	Урамшуулал	12,610,400.00	23,065,330.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,789,300.00	51,789,300.00
210201	Тэтгэврийн даатгал	35,216,600.00	35,216,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,143,200.00	4,143,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,314,600.00	3,314,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	828,600.00	828,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,286,300.00	8,286,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,600,000.00	

			67,045,007.31
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	11,011,841.31
210302	Түлш, халаалт	51,600,000.00	38,753,166.00
210303	Цэвэр, бохир ус	26,000,000.00	17,280,000.00
2105	Нормативт зардал	86,578,900.00	84,998,684.00
210502	Хоол, хүнс	86,578,900.00	84,998,684.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,900,000.00	24,054,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,900,000.00	11,900,000.00
210604	Урсгал засвар	25,000,000.00	12,154,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.00	1,109,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	1,109,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,542,400.00	20,541,384.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,212,400.00	17,211,484.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,330,000.00	3,329,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,027,000.00	11,027,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,027,000.00	11,027,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,027,000.00	11,027,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	710,194,700.00	679,794,647.38
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	710,194,700.00	679,794,647.38
122005	Орон нутгийн төсвөөс	710,194,700.00	679,794,647.38
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	33,559,670.91
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37.00	34.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	19.0
620003	Үйлчлэх ажилтан	15.00	14.0
298.0	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	298.0	260.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн зорилго "Хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүй урлаг, уран сайхан, сэтгэн бодох чадварыг хөгжүүлж байгаль орчин юмс үзэгдлийн талаар анхдагч зөв ойлголтыг олох, бие даасан мэдлэг

чадвар дадал олгоход оршино” гэсэн зорилгын хүрээнд иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал “Заавар батлах тухай”
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дугаар тушаал “Заавар батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.514.5 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	33,559.6	33,559.6
Авлага	-	-	-
Бараа материал	45,178.5	51,046.2	5,867.7
Үндсэн хөрөнгө	2,412,135.1	2,370,193.2	41,941.9
Нийт хөрөнгө	2,457,313.7	2,454,799.2	
Өр төлбөр	0	277.0	277.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,457,313.7	2,454,522.2	2,791.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,457,313.7	2,454,799.2	2,514.5

- Мөнгөн хөрөнгө данс: 33,559.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй үлджээ. Энэ нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7¹-д заасны дагуу дээд шатны төсөвт төвлөрүүлэхгүйгээр үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.
- Нийт орлого 2,714,193.1 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн өмчийн өөрчлөлтийн тайлан дээр үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дээр нэмэгдүүлсэн, мөн бараа материалын эхний үлдэгдлийг үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого дээр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгаас 128,600.0 мянган төгрөг, улсын төсвөөс 628,502.4 мянган төгрөг нийт 757,102.4 мянган төгрөг, зарлагыг 757,102.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 46,622.7 мянган төгрөгөөр бууруулж, 710,479.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 566,210.9 мянга, орон нутгийн төсвөөс 113,583.2 мянга, төсөвт байгууллагын орлого 485.0 мянга нийт 680,279.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 628,881.8 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардал 17,837.6 мянган төгрөгийг зарцуулж 33,559.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

¹ Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ;

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,500.0	1,500.0	0	100%
1	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	86,578.9	84,998.6	1,580.2	98.1%
2	81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,709.8	2,709.8	-	100%
3	81823-Боловсролын байгууллагын багш , ажиллагсдын мэргэжил дээш	1,500.0	1,500.0	-	100%
4	81834-Боловсролын стандарт ,сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	407,878.8	376,099.3	31,779.4	92.2%
5	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	66,043.4	66,043.4	-	100%
6	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	285.0	485.00	-200.0	100%
7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	109,600.0	79,200.0	30,400.0	78.9%
8	80112-Нийтлэг үйлчилгээ	22,483.8	22,483.7	0.5	100%
9	Ангилалдаагүй бусад зардал	11,900.0	11,900.0	-	100%
НИЙТ		710,479.7	646,719.8	63,759.9	91.0%

Төрийн өмчийн барилгын тогтмол зардалын санхүүжилт 78.9, хувьтай хэрэгжсэн нь санхүүжилт 30,400.0 мянган төгрөгөөр дутуу , боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл 92.2 хувьтай хэрэгжсэн нь орон тоо дутуугаас цалингийн зардлын хэмнэгдсэнтэй холбоотой байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК –ны аудитор О.Цагаан, гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Бүзмаа, хяналтыг Сүхбаатар аймаг дахь аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 552,600.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,289.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн түвшинд 75 хувиар буюу 6,216.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1², 15.2.3³-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 178.3-14181.4 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: гэрэл цахилгааны зардал 3,772.5 мянган төгрөгөөр өсөлттэй, цэвэр бохир ус 10,931.3 мянган төгрөгөөр хэмнэлттэй, бараа үйлчилгээний бусад зардал 14,181.4 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 178,3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Гэрэл цахилгаан , ус, халаалтын зардал* өмнөх оноос өссөн нь 2021 онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж гэрэл цахилгаан, халаалт цэвэр бохир усны зардал бага гарч байсан бол тайланд онд үйл ажиллагаа хэвийн явагдсанаас зардал өссөн байна.
- Бараа үйлчилгээний бусад зардлууд дотор тээвэр шатахуун, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, хангамжийн бараа материал зэрэг зардлуудыг нийлүүлэх төсвийн төлөвлөлт, зардлын ангилалд өөрчлөлт орсон, мөн бараа материалын үнэ урд оноос 2-3 дахин өссөн нь нөлөөлөл үзүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

² байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

³ сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томиллолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс, хугацаандаа оруулсан 127 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 20, хугацаа болоогүй 4 мэдээ байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6⁴дугаар зүйлийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэг нь нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын хүүхдийн цэцэрлэгт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 .Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	40,000.0	1	40,000.0	100
Зөвлөмж	2	-		-	
Нийт дүн	3	40,000.0	1	40,000.0	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 25,640.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг залруулав.

5.1 Залруулсан алдаа:

Санхүүгийн программын шинэчлэлтэй холбоотойгоор хөрөнгийн элэгдэлийг 1-4 сард бодуулаагүй орхигдуулж байдлын тайлангийн үлдэгдэл илүү, үр дүнгийн тайлангийн зардлыг дутуу тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС 17 үндсэн хөрөнгийн 66 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн элэгдүүлэх дүнг ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

⁴ Шилэн дансны мэдээлэл

Залруулсан алдаа: Хөрөнгийн элэгдлийг 1-4 сард бодуулаагүй орхигдуулж байдлын тайлангийн үлдэгдэл илүү, үр дүнгийн тайлангийн зардлыг 25,640.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулан, санхүүгийн тайланд элэгдлийг бүрэн тусгуулав.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Гэрэл цахилгаан, цэвэр бохир ус зэрэг байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд өмнөх оноос 48.0 хувиар өссөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15.2.1 " байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй аргаар төлөвлөж, зарцуулах/ гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.1 "байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай , хэмнэлттэй аргаар төлөвлөж, зарцуулах /гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

5.3.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс, хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 20, мэдээллийн хугацаа нь болоогүй 4 байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6⁵ дугаар зүйлийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах.

5.3.2 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 34 нэр төрлийн 242 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна

Энэ нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС-3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалтийг зөрчсөн байна.

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

⁵ Шилэн дансны мэдээлэл

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу бодсон	1	25,640.1			1	25,640.1	1	25,640.1				
Дүн	1	25,640.1			1	25,640.1	1	25,640.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 34 нэр төрлийн 242 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	1	0						1	0				
Гэрэл цахилгаан, цэвэр бохир ус зэрэг байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд өмнөх оноос 48.0 хувиар өссөн	1	14,703.8			1	14,703.8							
Дүн	2	14,703.8			1	14,703.8	1	0					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
www.shilendans.gov.mn цахим хуудсанд 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн	1	0									1	0
Дүн	1	0									1	0

